

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 1

Улаанбаатар хот

*Хурлын ирцийг батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Тооллогын комиссын дүнг үндэслэн “Эм Эн Ди” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.

Хурлын ирц хангалттай тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хурлын дэгийн дагуу явуулахыг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА:



Н.ГАНЧИМЭГ/

# “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 2

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг сунгах  
тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн “Эм Эн Ди” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

“Эм Эн Ди” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг сунгасугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр:

1. Намсрайн Отгон-Од
2. Пионг Чунг Фах (Piong Choong Fah)
3. Чунг Чии Иенн (Chung Chee Yenn)
4. Лю Вен Тейк (Lew Wen Teik)
5. Намсрайн Ганчимэг
6. Бадамсамбуугийн Баярсайхан

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. Цэрэндоржын Болд
2. Оюунгэрэлийн Мөнхдалай
3. Баяр-эрдэнэгийн Сарнай

“Эм Эн Ди” Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг компанийн үйл ажиллагаа сайжирч, компани ашигтай ажиллаж эхлэсэн хугацаанаас ТУЗ-ийн цалин урамшууллыг дахин хэлэлцүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Н.ГАНЧИМЭГ/

## “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 3

Улаанбаатар хот

*Үйл ажиллагааны тухай*

2021 оны ажлын төлөвлөгөөний дагуу Говь алтай аймгийн Тайшир суманд уул уурхайн операторын үйл ажиллагааг эрхлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж, Мөн компанийн үйл ажиллагаа идвэхижүүлэх зорилгоор нэмж хувьцаа гаргахаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Гүйцэтгэх захирал Н.Отгон-Од-д зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА:



Н.ГАНЧИМЭГ /

**“ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№4

Улаанбаатар хот

*Гүйцэтгэх захирлын бүрэн эрх,  
цалин урамшуулал*

Компанийн тухай хуулийн 62 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Тус компанийн Гүйцэтгэх захирал Намсрайн Отгон-Од-ын бүрэн эрхийг сунгаж, үргэлжлүүлэн ажиллуулах бөгөөд цалин урамшууллын хэмжээг компанийн үйл ажиллагаа сайжирч, компани ашигтай ажиллаж эхлэсэн хугацаанаас Төлөөлөн удирдах зөвлөл дахин хэлэлцэхээр тогтсугай.

ХУРЛЫН ДАРГА:



/Н.ГАНЧИМЭГ/

## “ЭМ ЭН ДИ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дугаар  
сарын 28-ны өдөр

№ 5

Улаанбаатар хот

*Компанийн жилийн үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайлангийн  
талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дүгнэлт, хараат бус аудитын  
дүгнэлтийг батлах тухай*

“ЭМ ЭН ДИ” Хувьцаат компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцэн баталж, Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, 46 дугаар зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн ноогдол ашиг тараахгүй болохыг тэмдэглэсүгэй.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 онд хийсэн ажлыг хангалттай гэж тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА:



Н.ГАНЧИМЭГ /